



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/75

Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.5, 3.6.9 дэх заалт, Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 6 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, байгаль хамгаалагчдын хувцас худалдан авах ажлыг ажлын хэсгийн 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 04 дүгээр хурлын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн байгаль хамгаалагчдын өвөл, зуны хээрийн хувцсыг “Эрхэм сүлд бэлэг” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай, өвлийн гутлыг иргэн Ш.Баттунгалагтай шууд худалдан авах гэрээ байгуулж гүйцэтгүүлсүгэй.

2.“Эрхэм сүлд бэлэг” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг сум дундын Ойн ангийн дарга (Д.Очирхуяг)-д даалгасугай.

3.Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, байгаль хамгаалагчдын өвөл зуны хээрийн хувцас худалдан авах зардалд шаардагдах 13,970,00 (арван гурван сая есөн зуун далан мянга) төгрөг, өвлийн гутал авахад шаардагдах 5,830,000(таван сая найман зуун гучин мянга) төгрөг, нийт 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгийг гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/